



## “БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”

### НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1 Богд банк энэ хугацаанд нэлээд олон асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Нийт 35 удаагийн хурлаар 65 асуудлыг цахимаар болон танхимаар хэлэлцсэнд оролцож саналаа хурлын тэмдэглэлд товч бичиж, хурлын шийдвэрт тусгуулан ажилласан.
- 1.2 Зээлийн олголт, төлөлттэй холбогдсон олон асуудлаар ТУЗ-ийн шийдвэр шаардлагатай болсон нь ТУЗ-ийг олон удаа, бас богино хугацаанд хуралдуулах, хэлэлцсэн асуудлаар тайлбар, тодруулга гаргуулах, үндэслэл, тооцооллыг нягт нямбай, ил тод, бодитойгоор гүйцэтгэхэд онцлон анхаарч шийдвэр гаргахыг шаардаж байсан.
- 1.3 Банкны 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2023 оны бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон хууль журмын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлууд, НҮБ-аас гаргасан банкны үйл ажиллагаатай холбогдсон конвенц, тогтоолууд, FATF-ийн зөвлөмжүүд, Волфсберг группээс гаргасан зарчмууд зэргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлуудад нэлээд их хүч хөдөлмөр хугацаа зарцуулсан.
- 1.4 “Богд банк” ХК-ийн нийт 1736 хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн бэлтгэл хангах, боловсруулах, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, ногдол ашгийн тооцоо хийх, хуваарилах санал бэлтгэхэд оролцож, хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай зохион байгуулагдсан.
- 1.5 Эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар батлахад саналаа зохих үндэслэлтэйгээр танилцуулсан.
- 1.6 Банкны 2023 оны 1 дүгээр улирлын ажлын дүнг хэлэлцэхэд 2022 оны энэ хугацаанд 3 (гурван) тэрбум төгрөгийн ашигтай байсан бол энэ оны 1 дүгээр улиралд 6 тэрбум төгрөг болж, банкны үйл ажиллагаа, үр дүн нэмэгдэн сайжирч байна.

### ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

- 2.1 Хорооны хурлыг 4 удаа хийж, 2023 оны аппетитын төсөл, чанаргүй активын стратеги, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, тогтворжуулах төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын хөтөлбөр болон Монголбанканд явуулах хугацаатай тайлан мэдээллүүд зэрэг асуудлыг хэлэлцэн ТУЗ-ийн хуралд оруулан шийдвэр гаргуулсан.
- 2.2 Банк нь харилцагчийн эрсдэл, газар зүйн байршил, улс орны эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх эрсдэл зэргийг сайтар судлан харилцагч тус бүрийн эрсдэлийг үнэлж ажиллах, урьд хийсэн үнэлгээгээ шинэчлэх арга хэмжээ авахыг гүйцэтгэх удирдлагад даалгасан.
- 2.3 Тусгай хяналтыг зааврын дагуу гүйцэтгэж, ялангуяа сэжигтэй гүйлгээ нэг бүрийг хянаж хугацаа алдалгүй арга хэмжээ авах, өндөр дүнтэй (10 сая төгрөгөөс дээш) гүйлгээнд бодит хяналтыг гүйцэтгэж тайлагнаж ажиллах үүрэг өгсөн.
- 2.4 Эрсдэлийн аппетит, чанаргүй активын бууралт, өөрийн хөрөнгийн өгөөж активын өгөөж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хөдөлмөрийн бүтээмж, зээл болон нийт активын харьцаа зэрэг үзүүлэлтүүдийн үндэслэлийг тухай бүр тооцож бодит биелэх нөхцөлийг хангах, 2022 оны тайлан, дүнгээр гарсан хувь хэмжээнээс бууруулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авч ажиллахыг банкны гүйцэтгэх удирдлагад даалгасан.

**Гурав. Аудитын хороо**

- 3.1 Аудитын хорооны хурлыг 2 удаа хийж, ДАГ-ын 2022 оны ажлын тайлан, ДАГ-ын 2023 оны ажлын төлөвлөгөө, ДАГ-ын дүрэм, ДА-ын үйл ажиллагааны журам, Богд банкны дотоод аудитын бодлого, банкны үндсэн үзүүлэлтүүдийн 1 дүгээр улирлын биелэлт, явц, анхаарах асуудал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын бодлого зэрэг асуудлуудыг хэлэлцэн саналаа ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.
- 3.2 ДАГ-ын төлөвлөгөөний явц, Богд банкны үйл ажиллагааны 1-р улирлын ажлын явц, төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үзүүлэлт зэргийг хэлэлцэн зохих шийдвэр гаргасан.

**Дөрөв. Санал, хүсэлт**

- 4.1 Банкны ажлын хүрээ, хэмжээ өсч харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх шаардлага нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд банкны өдөр тутмын ажил боловч гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээнээс /зээл, батлан даалт, зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөр г.м/ хэтэрсэн олон асуудал гарч, тэр бүхнийг яаралтайгаар ТУЗ, түүний хороодод танилцуулан шийдвэр гаргах явдал нэлээд төвөгтэй, багагүй чирэгдэлтэй, ТУЗ-ийн ажилд ч хүндрэлтэй байгааг харгалзан хууль зөрчихгүйгээр эдгээр асуудлыг шийдэх, хөнгөвчлөх ямар арга зам, боломж байгаа талаар Монголбанкнаас зөвлөмж, аргачлал өгөх, шаардлагатай бол журамлах арга хэмжээ авахыг хүсэж, санал болгож байна.

Богд банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн  
АХ, ЭУХ-дын дарга:  
2023.07.06

/Э.Бямбажав/